



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 11

Арвайхээр


Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө, батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 бүлэг, 95 зорилт, арга хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. ИТХурлын дэргэдэх “Иргэний танхим”-д 2017 онд зохион байгуулах төлөвлөгөөг 2 бүлэг, 25 ажлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Сумын ИТХурлаас батласан холбогдох журмуудын хүрээнд дээрх төлөвлөгөөнүүдийн зорилт, арга хэмжээг цаг хугацаанд нь хариуцлагатай зохион байгуулж, хэрэгжилтийн үр дүнг 2017 оны 12 дугаар сард ИТХурлын Төлөөлөгчдийн хуралдаанд тайлагнахыг Хурлын ажлын албаны дарга /Ц.Тунгалаг/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.АМАРТҮВШИН